

## УЛААНБААТАРЫН БАГА ХУРАЛ

Олон улсын харилцааны шинэ философи буюу улс төрийн шинэ сэтгэлгээний ачаар дэлхийн улс төрийн байдалд нааштай ахиц өөрчлөлт гарсаар байна. Улс төрийн бодлогыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулах, дэлхий дахины бодлогод эрдэмтдийг оролцуулах хандлага өнөөгийн олон улсын харилцаанд чухал байр эзэлж байна. Ийм нөхцөлд энэ 1988 оны 10-р сарын 5—6-нд Улаанбаатар хотноо «Улс төрийн шинэ сэтгэлгээ: Ази-Номхон далайн бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлын асуудлууд» сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал боллоо. БНМАУ-ын ШУА-ийн Дорнодахины судлалын хүрээлэнгээс эрхлэн зохион байгуулсан энэ бага хуралд БНБАУ, БНСВУ, БНАГУ, ЗХУ, БНКУ, БНМАУ, БНПАУ, БНУАУ, БНСЧСУ-ын нэрт эрдэмтэд, дорно дахинч, олон улсын харилцааны мэргэжилтнүүд оролцлоо.

Бага хуралд оролцогчид өнөө үед улс төрийн шинэ сэтгэлгээний үрээр олон улсын харилцаанд нааштай хандлага гарч буй нөхцөлд Ази-Номхон далайн бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэх шинэ арга замыг хамтаар эрж хайх, түүнийг амьдралд хэрэгжүүлэхэд эрдэмтдийн үүрэг, оролцоо чухал бөгөөд чухам үүнд тус бага хурлын зорилго оршиж байгааг онцлон тэмдэглэжээ.

Дэлхий дахины улс төр, эдийн засгийн бодлогод Ази-Номхон далайн бүс нутгийн гүйцэтгэх үүрэг роль ямагт өсөн нэмэгдсээр байгааг ШУА-ийн ДДСХ-ийн захирал, түүхийн ухааны доктор Ш. Сандаг бага хурал дээр тавьсан илтгэлдээ тэмдэглээд үүний зэрэгцээ тус бүс нутагт цэрэг, улс төрийн сөргөлдөөнт байдал хэвээр үргэлжилж байна гэв. Иймээс энэ бүс нутагт цэргийн эвсэл байгуулах, зэвсэглэлээр хөөцөлдөхийг эгнэгт таслан зогсоох, олон талын болон хоёр талын харилцааг идэвхжүүлэх, аливаа асуудлыг улс төрийн аргаар зохицуулах талаар улс төрийн шинэ сэтгэлгээнд тулгуурласан шинэ бодит алхам эрс зоригтой хийх цаг нэгэнт болсоныг илтгэгч тэмдэглээд энэ үүднээс М. С. Горбачевын Красноярскт дэвшүүлсэн долоон зүйлт шинэ санал, санаачилгын ач холбогдлыг өндөр үнэллээ. Тэрээр орчин үеийн олон улсын харилцаанд олон шинэ зүйл гарч байгаагийн дотор БНХАУ-ын гадаад бодлого, олон улсын байр суурийн талаар дурьдахгүй өнгөрч болохгүй. Социалист Хятад улс цөмийн зэвсэг түрүүлж хэрэглэхгүй гэдгээ зарлаж, ЗХУ, БНМАУ зэрэг орнуудтай 2 талын харилцаагаа хэвийн болгож хөгжүүлэх талаар зарим тодорхой ахиц гаргаж, Паротонгийн гэрээнд нэгдсэн зэрэг нь Ази, Номхон далайн энх тайван, аюулгүй байдлыг ханган бэхжүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх үйлсэд оруулж буй хувь нэмэр мөн гэж тэмдэглэлээ.

Ази-Номхон далайн бүс нутагт энх тайван, аюулгүй байдлыг тогтоох арга зам бүс нутгийн олон улсын харилцаанд улс төрийн шинэ сэтгэлгээг хэрэгжүүлэх асуудлаар ЗХУ-ын ШУА-ийн Алс Дорнодын хүрээлэнгийн захирал, философийн ухааны доктор М. Л. Титаренко, Болгарын ШУА-ийн орчин үеийн нийгмийн онолын институтын орлогч захирал философийн ухааны доктор Т. Трендафилов, ККН-ын дэргэдэх Ази, Далайн орнуудын судалгааны төвийн захирал профессор М. Эрнандес нар илтгэл тавилаа. Д-р М. Л. Титаренко; өргөн уудам энэ бүс нутагт өрнөж буй өргөн далайтай, нарийн төвөгтэй үйл явц нь Алс Дорнод

ер нь Ази-Номхон далайн бүс нутгийн түгшүүрт байдлыг үндсээр нь эрүүлжүүлэхэд чиглэсэн социалист орнуудын санал санаачилгыг урагшлуулах практик зөвлөмжийг боловсруулах, тухайн асуудлыг гүн гүнзгий дүгнэсэн, хамтын бүтээл туурвих явдал онцгой чухал болохыг харуулж байна гэж онцлон тэмдэглэлээ. д-р Т. Трендафилов (Болгар) энэ санааг дэмжин энэ бүс нутагт оршин суугаа ард түмэн бүр улс төрийн шинэ сэтгэлгээний байр суурин дээр зогсож, нийгмийн хөдөлмөрийн хуваарилалтыг өргөн хөгжүүлэхийн тулд мөн байгалийн асар их нөөцтэй, хүн хүчний бололцоотой энэ бүс нутгийг энх тайвны бүс болгох, энх тайван, ардчилал, нийгмийн дэвшлийн тулд бат тогтвортой харилцан ашигтай хамтын ажиллагааны цогцолбор программыг боловсруулж болох юм гэжээ.

Бага хуралд оролцсон БНМАУ-ын ГЯЯ-ны орлогч сайд Х. Олзвой ЗХУ-ын ШУА-ийн Алс Дорнодын институтийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, дэд эрдэмтэн Ю. С. Столяров нар Ази-Номхон далайн бүс нутгийн улс орнууд эдийн засгийн салбарт бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх нь энэ бүс нутагт олон улсын аюулгүй байдлын систем бий болгох, харилцан ойлгох, итгэлцлийг бэхжүүлэх чухал урьдчилсан нөхцөл мөнийг тэмдэглэсэн юм. Ялангуяа социалист орнууд Ази-Номхон далайн бүс нутгийн орнуудтай худалдаа-эдийн засгийн хэлхээ холбоогоо өргөжүүлэх талаар идэвхтэй ажиллах хэрэгтэй байна гэсэн дүгнэлтийг илтгэгчид тус тус хийсэн байна.

Бүс нутгийн тулгамдсан асуудлууд, тухайлбал, Ази-Номхон далайн бүс нутаг дахь улс төрийн шинэ нөхцөл, Солонгосын хойгийн байдал зэрэг олон асуудлаар хуралд оролцогчид өргөнөөр санал бодлоо солилцлоо.

Ах дүү социалист орны эрдэмтэд ийнхүү Ази-Номхон далайн бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг ханган бэхжүүлэх асуудлаар санал бодлоо ил тод, ардчиллын үндсэн дээр чөлөөтэй солилцож, цаашид энэ салбарт судалгааны ажлыг гүнзгийрүүлэх, үр ашигтай хамтран ажиллах нь чухал гэдэгт санал нэг байгаагаа илэрхийллээ. Олон улсын нөхцөл байдалд шинжлэх ухааны үүднээс нарийн дүн шинжилгээ хийх, улс төрийн ээдрээ төвөгтэй үйл явдлыг диалектикаар гүн гүнзгий урьдчилан харж, нийт хүн төрөлхтний эрх ашгийг урьтал болгохын чухлыг олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд оролцогчид онцлон тэмдэглэлээ. Өргөн уудам энэ бүс нутгийн ээдрээ төвөгтэй өнөөгийн байдлыг эрүүлжүүлэх, энэ үйлсэд социалист орнуудын оруулж буй хувь нэмрийг бататгахад Улаанбаатарын бага хурал бас нэг чухал алхам боллоо.

Улаанбаатарын бага хуралд оролцогчид Ази-Номхон далайн бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлын асуудал, бүс нутгийн ард түмний түүх, соёлын судалгааг өргөжүүлэх зорилгоор Дорнод Азийн судалгааны холбоо байгуулахаар шийдвэрлэв. Энэ холбоонд сонирхогч социалист орнууд элсэж болох бөгөөд түүний үйл ажиллагаанд Ази-Номхон далайн бүс нутгийн аль ч улс орнууд оролцож болох юм гэж хуралд оролцогчид үзлээ.

**Л. Бэгзжав**